

Монголд авилгалыг хориглоход анхаарах зарим асуудал

*Ж.Тортөгтох, Ph.D, МУИС, НШУС, Орчин үеийн улс төрийн
судалгааны төвийн захирал*

Ч.Өлзийсайхан МУИС, НШУС, Улс төр судлалын тэнхмийн ахлах багш

Д.Оюунчимэг, МУИС, НШУС, Улс төр судлалын тэнхмийн ахлах багш

Энэхүү судалгааны зорилго нь авилгалыг яаж арилгах вэ, түүнийг алга болгоход юу юу нөлөөлж болох вэ гэдэг дээр олон түмний санаа бодлыг гаргаж харуулахад голлон анхаарав. Судалгаанд хамрагдагсад авилгалыг таслан зогсооход чиглэсэн хатуу хууль гаргаж хэрэгжүүлэх гэсэн хүчин зүйлийн 90.3 хувь нь маш их ач холбогдолтой, болон ач холбогдолтой гэж үзжээ. Энэ нь нийт ард иргэд авилгал гэдэг энэ гэж үзэгдлээс залхсан, түргэн салахыг эрмэлзсэн, өөрсдийнх нь амьдрал үйл ажиллагаанд үргэлж саад тотгор болж байгааг их мэдрэх болсонтой холбоотой юм. Түүнээс гадна авилгалын асуудлыг олон жил яриад л байсан тэр нь тодорхой үр дүнд хүрсэн нь харагдахгүй, байдал улам л дордож байгаагаас улбаатай болов уу.

Тоон судалгаанд оролцогсад авилгалыг өөгшүүлэгч эдийн засгийн хүчин зүйлсэд иргэдийн орлогын тэгш бус байдал гэж 29.6 хувь нь үзсэн. Гэтэл чанарын судалгаанд оролцогсад энэ үзүүлэлтийг дурдсангүй.

Тоон судалгаа чанарын судалгаа хоёрын үзүүлэлт хамгийн их зөрөөтэй гарч байгаа асуудлуудын нэг нь зан заншил, ёс суртахууны хүчин зүйлсийн талаар байлаа. Тоон судалгаанд оролцогсад 60.4 хувиар хүмүүсийн ёс суртахууны үүрэг хариуцлага суларсан нь авилгалыг өөгшүүлж байна гэж үзсэн бол чанарын судалгаанд оролцогсад нь ёс суртахууны хүчин зүйл бараг нөлөөлөхгүй, нөлөөлөх байсан ч бусад хүчин зүйлтэй харьцуулахад хамгийн сүүлд л нөлөөлнө. Нийгэм нь өөрөө ямар ч шударга хүнийг эвдээд байна шүү дээ гэсэн хариулт өгч байв.

Чанарын болон тоон судалгаа хоёулаа монголын нийгэмд авилгал түгээмэл үзэгдэл болсныг харуулж байна. Судалгаагаар авилгалыг илрүүлж чадахгүй байгаагийн учир шалтгаан юу вэ гэсэн асуултанд оролцогсдын 52 хувь нь төрийн байгууллага, албан тушаалтнууд авилгалд идэгдчихсэн, хоорондоо холбоо сүлбээтэй болчихсон, бие биенээ хамгаалдаг болчихсон байдал гэж үзэж байна. Тийм ч учраас авилгал, хээл хахуулийн асуудал нийгмийн хамгийн эмзэг асуудал болж, түүнийг шийдвэрлэх явдалд дорвитой ахиц гарахгүй байна. Судалгааны дүнгээс харахад олон түмэн авилгалтай тэмцэх ажлыг илүү оновчтой үр дүнтэй болоосой гэж хүсч явдаг нь харагдаж байна.

Түлхүүр үгс. Авилгал, ёс суртахуун, үүрэг, хариуцлага

Оршил

Энэхүү өгүүлэл нь¹ МУИС-ийн Орчин үеийн улс төрийн судалгааны төвөөс эрхлэн гүйцэтгэсэн “Авилгалыг дэмжигч болон хориглогч хүчин зүйлсийн судалгаа” төслийн хүрээнд хийгдсэн тоон ба чанарын

судалгааны харьцуулсан анализын үр дүнд тулгуурлан бичигдсэн болно. Уг судалгааны гол дүгнэлт нь нэгдүгээрт: 8 аймаг, нийслэлийн 6 дүүргийн төлөөлөл бүхий хот хөдөөг хамарсан нийт 500 гаруй түүвэр бүхий тоог судалгаа; хоёрдугаарт: тоон судалгааны үр дүнг бататгах, шалгах,

¹ Энэхүү өгүүлэл нь МУИС-ийн Азийн Судалгааны төвийн санхүүжилтээр 2006.04.01-2007.03.31 ний хооронд МУИС-ийн Орчин үеийн улс төрийн судалгааны төвөөс эрхлэн гүйцэтгэсэн “Авилгалыг дэмжигч ба хориглогч хүчин зүйлсийн судалгаа” төслийн үр дүнд тулгуурлан бичигдсэн болно. Дашрамд тэмдэглэхэд, төслийн үйл ажиллагааг санхүүжүүлсэн МУИС-ийн Азийн Судалгааны төвд төслийн багийн нийт гишүүд гүн талархлаа илэрхийлж байна.

тоон судалгаагаар илрээгүй судалгааны таамаглалыг тандах, судалгаагаар дэвшүүлсэн асуудлыг илүү нарийвчлан гаргах зорилгоор хийсэн фокус-группын ярилцлагын дүгнэлтүүдэд үндэслэгдэж байгаа болно. Чанарын болон тоон судалгаа хоёулаа монголын нийгэмд авилгал түгээмэл үзэгдэл болсныг харуулж байна.

Авилгал нь ардчиллын хөгжил цэцэглэлтэнд муу нөлөө үзүүлээд зогсохгүй ардчиллын замаас ухрахад ч хүргэх аюултай бөгөөд Монголчуудын санааг хамгийн ихээр зовоож буй асуудал болохын хувьд² судлаачид, иргэд, улс төрчид, олон улсын байгууллагуудын анхаарлыг татах болжээ.

Авилгалын асуудлыг шинжлэх ухааны онол арга зүйн үүднээс нарийвчлан судлах зүй ёсны шаардлагатай гэдэг нь өнөө цаг үед нэгэнт тулгамдсан асуудал болж байна. 2005 онд АНУ-ын ОУХА-аас хийгдсэн “Монгол улс дахь авилгалын байдалд хийсэн үнэлгээ” судалгаанд авилгал Монголд газар авч эхэлж байгаа нь илэрхий байна³ хэмээн тэмдэглэгдэж байсан бол харин МУИС-ийн Азийн Судалгааны төвийн санхүүжилттэйгээр хийгдсэн энэхүү төслийн хүрээнд хийгдсэн олон шатлалт ахисан түвшний судалгаанаас харахад авилгал “ноцтой” байдалд хүрсэн болох нь харагдаж байна.

Тоон болон чанарын судалгааны харьцуулалт, нэгдсэн анализ

Нийгмийн өөрчлөлт шинэчлэлт эхэлсэн үеэс хойш Монголд авилгал, хээл хахууль улсын өмчит аж ахуйн нэгжүүдийн хувьчлал, улмаар газрыг хувьчлах үйл явцад илрэх болжээ. Өнөөгийн нөхцөлд банк, уул уурхайн салбар авилгал үүсэн гарах боломжтой салбаруудад тооцогдож байгаа бол, шүүх ба хууль эрх зүйн салбар, гааль, тендерийн асуудал өндөр эрсдэлтэйд тооцогдсоор байна. Ийнхүү эрсдэлтэй хэсгийг салбаруудаар нь тооцон гаргахаас гадна төвшингөөр нь ялган зааглаж авч

үзэх нь арга зүйн хувьд илүү оновчтой юм. Үүнд бид авилгал, түүнийг дэмжигч болон хориглогч хүчин зүйлсийг судлахдаа дээд түвшний болон дунд шатны буюу өөрөөр хэлбэл, улс төрийн түвшний болон захиргааны түвшний гэж ялган зааглаж авч үзсэн болно. Монгол улсын хувьд захиргааны болоод улс төрийн түвшний аль алинд нь байгаа авилгач байдлыг хазаарлах талаар үр ашигтай арга хэмжээнүүдийг нэн түрүүнд авах шаардлагатай байна.

Чанарын судалгаанд оролцогчдоос нэг ч хүн монголын өнөөгийн нийгэмд авилга байхгүй гэж үзээгүй байна. Тоон судалгаанд нийт оролцогчдын 96.6 хувь нь ийм саналтай байсантай харьцуулахад өндөр хувьтай гарчээ. Чанарын судалгаанд оролцогчид нь тоон судалгаанд хамрагдагсдаас хэт цөөн байгаа нь ийм өндөр хувьтай гарахад нөлөөлсөн. Чанарын болон тоон судалгаа хоёулаа монголын нийгэмд авилгал түгээмэл үзэгдэл болсныг харуулж байна. Чанарын судалгаанд оролцогчид нь саналаа чөлөөтэй илэрхийлж ярилцаж байгаа учраас хэн нэгнийхээ ярьсан зүйлийг давхардуулж ярихгүй гэсэн тал их ажиглагдаж байгаа тул тэдний санаа бодлыг процентоор илэрхийлэх боломжгүй. Харин зарим тохиолдолд нэгнийхээ эсрэг байр суурьтай байгаа тохиолдолд түүнийг тусгайлан анхаарч судалгааны дүгнэлт, зөвлөмжийн хэсэгт тусгасан болно.

Чанарын судалгаанд оролцогчид эхний асуулт болох авилгалын хэргийг илрүүлэхэд саад болж буй гол гол зүйлсийг тодорхойлсон байдлыг авч үзье. Улс төрийн өндөр албан тушаалтнууд бие биетэйгээ авилгалын сүлжээгээр холбогдчихсон. Хэн нэг нь асуудалд орлоо гэхэд бие биенийгээ хамгаалчихдаг, том улс төрчид хамгаалдаг тул шийтгэгдлээ гэхэд суллагдах, өршөөгдөх магадлал өндөр, хуулийн заалтууд нь авилга өгсөн, авсан, зуучилсан бүгдийг нь шийтгэдэг учраас илрэх боломжгүй болгодог. Улс төр нь мөнгөтэй хэт их хутгалдсан, шүүх цагдаагийн байгууллага ч улс төрчидтэй холбоотой, авилгалын

² AsiaBarometer 2005 survey: Mongolia profile

³ United States Agency International Development, Assessment of Corruption in Mongolia, 19 August 2005 Final Report

хэргийг нуун дарагдуулах тал руугаа их үйл ажиллагаа явуулдаг. Шүүх цагдаагийн байгууллага нь өөрөө авилгалд идэгдчихсэн. Бүх хүн өгөх, авах сэтгэлгээтэй болчихсон, хүмүүс өөрийн ажил нь бүтэж байгаа тул авилга өгч байна гэж сэтгэл нь зовдоггүй. Албаны бюрократ бүтэц нь өөрөө ийм байдал руу түлхэж байна гэж хариулжээ. Чихэрийн цуглуулга, дарс гэх мэт зүйл нь авилга мөн үү гэдгийг ялгаж салгаж ойлгох хэрэгтэй гэж үзсэн байна.


Авилгалын хэргийн илрүүлэлт хангалтгүй байгаад нөлөөлж буй шалтгаанууд гэсэн дээрх асуултанд тоон судалгаанд оролцогсод дараахь байдлаар хариулт өгсөн юм. Үүнд: Албан тушаалтнуудад хууль үйлчилдэггүй тогтолцоо хэвшмэл болсноос гэж нийт оролцогчдын 26.4 хувь, авилгалыг илрүүлэх төрийн байгууллагууд нь авилгалд идэгдсэнээс гэж 25.6 хувь, авилгалын талаархи хууль, эрх зүйн систем бэхжээгүй гэж 20.1 хувь, хүмүүсийн ёс суртахуун доройтож, нийгмээрээ авилгал өгөх, авах сэтгэлгээнд автсан гэж 27.0 хувь бусад шалтгаанаар гэж 1 хувь нь хариулсан байв (Зураг 1).

Чанарын болон тоон судалгааг харьцуулан авч үзвэл аль аль судалгаа нь авилгалын илрүүлэлт хангалтгүй байгаад нөлөөлж буй шалтгааныг адилхан харуулжээ. Харин чанарын судалгаанд тоон судалгаанд гарч ирээгүй албан тушаалтнуудын хоорондын


сүлжээгээр холбогдсон байдал, хэн нэг нь шийтгэгдлээ гэхэд түүнийг нь хамтаараа нуун далдлах, шийтгэлийг нь хөнгөрүүлэх, үгүйсгэх арга барилтай болсон явдал авилгалын хэргийн илрүүлэлт хангалтгүй байгаад нөлөөлдөг томоохон шалтгаан гэж үзжээ.

Судалгаанд оролцогчдоос авилгалыг алга болгоход нөлөөлөх хүчин зүйлсийн талаар ямар санаа бодолтой байгааг асуусан юм. Зураг 2-оос харахад тоон судалгаанд хамрагдагсдын 46.2 хувь нь авилгал авдаг болон өгч буй этгээдэд хүлээлгэх шийтгэлийг бий болгох явдал маш их ач холбогдолтой, 29.6 хувь нь ач холбогдолтой гэж үзсэн байна. Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм батлаж сахиулахыг маш их ач холбогдолтой гэж 47.7 хувь, ач холбогдолтой гэж 36.3 хувь, олон нийтийн талаар энэ талын сурталчилгаа хийхийг маш их ач холбогдолтой гэж 41.2 хувь, ач холбогдолтой гэж 33.5 хувь, авилгалтай тэмцэх тусгай байгууллага байгуулж ажиллуулахыг маш их ач холбогдолтой гэж 35.7 хувь, ач холбогдолтой гэж 35.9 хувь үзжээ. Тоон судалгаанд оролцогчдын хамгийн их ач холбогдол өгсөн зүйл нь авилгалыг зогсооход чиглэсэн хатуу хууль гаргаж хэрэгжүүлэх явдал гэсэн байлаа. Нийт оролцогчдын 61.5 хувь нь энэ арга хэмжээг маш их ач холбогдолтой гэж, 27.8 хувь нь ач холбогдолтой гэж үнэлсэн байгаа нь нийт оролцогчдын 89.3 хувь болж байна.

Зураг 1. Судалгаанд хамрагдсан хүн амын хувийн жин, авилгалын хэрэг илрүүлэлт хангалтгүй байгаад нөлөөлж буй шалтгаанаар



Зураг 2. Судалгаанд хамрагдсан хүн амын хувийн жин, авилгал, хээл хахуулийг багасгахад ач холбогдолтой хүчин зүйлсийг үнэлсэн байдлаар



Тэгвэл энэ асуудлыг чанарын судалгаанд оролцогчид хэрхэн авч үзсэнийг харьцуулан үзье. Чанарын судалгаанд хамрагдагсад хамгийн их анхаарал тавьсан, авилгалыг арилгахад нөлөөлөх чухал ач холбогдолтой гэж тооцсон зүйл нь шийтгэлийг хатуу болгох, гэхдээ өгсөн авсан хоёуланг нь биш харин авсныг нь хатуу шийтгэдэг хуультай болох явдал гэж үзсэн байна. Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм батлаж мөрдүүлэх гэсэн тоон судалгааны дүнтэй нэлээд дөхөж очихуйц санал болох бюрократуудын сэтгэлгээг өөрчлөх явдал чухал гэж үзжээ. Гэхдээ энэ санал төдийлөн их давтагдахгүй байгаа, мөн ийм хууль, дүрэм батлан гаргах хэрэгтэй гэж дурдахгүй байгаа нь чанарын судалгаанд хамрагдагсад энэ зүйлд нэг их ач холбогдол өгөхгүй байгааг харуулж байна. Харин ч эсрэгээрээ дээд түвшинд байгаа авилгалыг бид нэгэнт арилгаж чадахаасаа өнгөрсөн, арилгахад их хэцүү гэж гутарсан санал нэлээд цухалзаж байлаа.


Судалгаанд оролцогчид төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг нэмэгдүүлэх нь төдийлөн үр дүнд хүргэхгүй, харин ч орлого нэмэгдэхийн хэрээр тансаг хэрэглээ нэмэгдэх тул энэ нь авилгалыг арилгах хүчин зүйл болж чадахгүй гэж үзэж байна. Одоо манай төр, засгаас чухал ач холбогдол өгч байгуулж байгаа авилгалтай тэмцэх байгууллага хэр зэрэг ач холбогдолтой байх талаар санал асуухад тоон судалгаанд хамрагдагсад маш их ач холбогдолтой гэсэн хариулт дээр хамгийн цөөн санал өгч байсан бол чанарын судалгаанд хамрагдагсад хэрэв ийм байгууллага байгуулах болвол иргэний төлөөлөл маягаар л зохион байгуулбал үр дүнд хүрч магадгүй, харин ямар нэг эрх мэдэл бүхий субъект томилдог байвал дахин нэг авилгал авдаг байгууллага л нэмэгдэнэ шүү дээ гэсэн санал гаргаж байлаа. Тэгэхээр хоёр судалгаа хоёулаа энэ арга хэрэгслэлийн үр дүнд эргэлзэж байгаа нь харагдаж байна. Чанарын судалгаанд хамрагдагсад төрийн албанд чадвар муутай хүмүүс их шургалдгаас

эдгээр хүмүүс мөнгө олох аргаа болгож авилгалыг цэцэглүүлж байна гэж үзжээ.

Хүмүүсийн дунд явуулах сургалт, сурталчилгааны ажил болон багаас нь авилгалгүй амьдрахаар хүмүүжүүлэх нь тодорхой үр дүнд хүргэж болно гэж үзэж байна. Гэхдээ чанарын судалгаанд оролцогчид авилгалын эсрэг хатуу хууль гаргаж, хуулиа хэрэгжүүлж, хатуу шийтгэл хүлээлгэх замыг л аль ч арга хэрэгслэлээс чухалчилж байна. Бусад зүйлсийг энэ арга замд хавсарга маягаар л хэрэглэх гэсэн байдлаар хандаж байлаа.

хувь нь эрүүл мэндийн салбарт, 37.1 хувь нь гаалийн байгууллагад, 32,0 хувь нь боловсролын байгууллагад, 28.4 хувь нь хууль сахиулах байгууллагад, 26.8 хувь нь төрийн захиргааны байгууллагад, 20.3 хувь нь татварын байгууллагад, 19.5 хувь нь мэргэжлийн хяналтын байгууллагад, 15.8 хувь нь банк, санхүүгийн байгууллагад ажиллагсад хахууль өгч байсан гэж хариулсан бол чанарын судалгаанд хамрагдагсад бараг бүгдээрээ өөрөө болон ойр дотныхон нь авилгал өгөх зайлшгүй хэрэгцээ гарсан гэж хариулжээ. Хэрвээ бид өнгөцхөн харах юм бол эрүүл

Зураг 3. Судалгаанд хамрагдсан хүн амын хувийн жин, авилгал авч, өгөх явдал тохиолдож байсан гэж нэрлэсэн байгууллагуудаар



Ямар байгууллагад авилга авах, өгөх явдал их байна, түүний учир шалтгаан юунд байна гэдгийг тодруулья. Судалгаанд оролцогчдоос танд болон танай ойр дотныхон хэн нэг албан тушаалтанд авилгал өгөх, эсвэл авах тохиолдол гарч байв уу гэсэн асуулт тавьсан юм. Тоон судалгаанд хамрагдагсдын хувьд нэрлэсэн байгууллагуудаар ангилан гаргаснаас хамгийн их хувийг эрүүл мэндийн болон гаалийн байгууллагад тохиолдож байсан гэсэн хариулт эзлэж байсан (Зураг 3). Тоон судалгаанд хамрагдагсдын 42.8

мэнд, боловсролын салбарт авилга өгөх явдал хамгийн их харагдаж байгаа юм. Эдгээр байгууллагуудын үйл ажиллагаа нь айл бүрийн бараг өдөр тутмын гэж хэлж болохуйц амьдралтай илүү ойр байдаг, бараг хүн бүрт хүртээлтэй байдаг онцлогийг харгалзан үзэх юм бол энэ байгууллагуудыг ийм олон хүн цохож хэлэх нь гарцаагүй. Гэтэл хил гааль давж явдаг хүмүүс нийт хүн амтай харьцуулахад хэр зэрэг өндөр хувьтай вэ, тэдгээр дотроо гаалиар татвартай бараа оруулж ирэх хүний тоо хэд билээ


гэж тооцоод анхаарч үзэх юм бол нийт оролцогсдын 37.1 хувь нь хахууль өгч үзсэн гэж хэлж байгаа гаалийн салбар бол хамгийн өндөр үзүүлэлттэйгээр авилгалд идэгдсэн байгууллага болж байна. Гэхдээ боловсролын байгууллагад сургуульд орох, хуурамч бичиг баримт бүрдүүлэх, багш нарт тал засах гэх мэтээр, эрүүл мэндийн салбарт эмч, сувилагч нараас байх ёстой хэм хэмжээнийх нь чанартай үйлчилгээг авахын төлөө өгч байгаа авилгал нь тооны олноор хүмүүсийн амьжиргаа, сэтгэлгээнд ихээхэн хохирол учруулж байгааг үгүйсгэхгүй байна. Мөн хууль сахиулах байгууллагад хахууль өгөх шаардлага гарах хүмүүсийн тоо нийт хүн амтай харьцуулахад бага мөртлөө судалгаанд оролцогсдын 28.4 хувь нь энэ салбарынханд авилгал өгсөн гэж үзэж байгаа нь бас л энэ байгууллага маш их авилгалд идэгдсэн болохыг харуулж байна. Мэргэжлийн хяналт болон татварын байгууллагынхан бас л яг иймэрхүү нөхцөл байдалтай байгаа нь эргэлзээгүй.

Фокус-группын ярилцлагын онцлог, уур амьсгалаас шалтгаалан оролцогчид санал бодол, мэдээллээ харамгүй хуваалцсан гэж ойлгож болно. Үндсэндээ чанарын судалгаанд хамрагдагсад бараг бүгдээрээ өөрөө болон ойр дотнынхон нь авилгал өгөх

зайлшгүй хэрэгцээ гарсан гэж хариулжээ. Ямар нэг зөвшөөрөл авах гэж, тендэрт ялах гэж, эмч сувилагч нараас сайн үйлчилгээ авахын тулд, цагдаа нарын дарамтаас гарахын тулд, сургуульд орохын тулд гэх мэтчилэн маш олон хэлбэрээр авилгал өгч байсан гэжээ. Тэднийхээр цаг алдаж, бөөн шат дамжлагаас нь залхаж, бюрократуудын хүнд суртлаас нь болоод ийм аргыг аргагүйн эрхэнд сонгосон гэж үзэж байна. Тэгэхээр судалгаанд оролцогсод монголын нийгэмд авилгал маш их түгээмэл үзэгдэл болсон гэдгийг зүгээр нэг баримжаагаар хэлсэн хэрэг биш өөрсдийн амьдралд тохиолдож байгаа бэрхшээлтэй байдлыг давах хамгийн хялбар арга болгон энэ замыг сонгох болсон гэдгийг бодитой баримтанд тулгуурлан хэлсэн хэрэг байлаа гэж үзэж болох юм.

Тэгвэл судалгаанд оролцогчид авилгалыг багасгах, хориглоход нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхой салбаруудаар хэрхэн авч үзэж байгааг харьцуулан авч үзье. Зураг 5-аас харахад судалгаанд хамрагдагсад энэ асуултанд 36.5 хувь нь авилгалын хэрэгт холбогдсон хүмүүсийг зохих хууль тогтоомжоор шийтгэж, шударга ёсыг нийгэмд хэвшүүлэх

Зураг 5. Судалгаанд хамрагдсан хүн амын хувийн жин авилгалыг хориглоход нөлөөлөх эрх зүйн хүчин зүйлийг нэрлэсэн байдлаар



анхаарах, 26.4 хувь нь авилгалын тухай хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, авилгалаас гарах сөрөг үр дагаврыг сайтар ойлгуулах гэж хариулжээ.

Эрх зүйн болон улс төрийн хүчин зүйлс зарим талаар давхцаж буй нь улс төр, эрх зүй хоёрын холбоо хамаарлаас урган гарч байгаа хэрэг юм. Хууль батлах, нэмэлт өөрчлөлт оруулах онцгой эрх бүхий УИХ, түүний гишүүдийг зөвхөн хуульчид, эсвэл зөвхөн улс төрчид байх ёстой гэх нь утгагүй. Тэгвэл авилгалын хүчин зүйлсийг хооронд нь огт холбоогүйгээр төсөөлөх нь дээрхийн нэгэн адил бас л боломжгүй зүйл юм. Чанарын судалгаанд хамрагдагсад авилгалын эсрэг хуулийн заалт нь өөрөө буруу байна. Авсан өгсөн хоёуланг нь шийтгэдэг нь авилгалыг илрүүлэх бололцоо олгохгүй байна. Авилгалтай тэмцэх байгууллагын удирдлагыг ард түмнээсээ сонгох эрх

ёстой. Төр юм бүхэнд оролцоод байгаа нь авилгалыг алга болгоход саад болоод байна гэсэн.

Чанарын болон тоон судалгаанд хамрагдагсад аль аль нь авилгалын эсрэг хуулийн заалтууд дутагдалтай байна гэж үзэж, түүнийг боловсронгуй болгох хэрэгтэй гэжээ. Авилгалын эсрэг хуулийг иргэдэд сурталчлах гэдэг дээр тоон судалгаанд хамрагдагсад бусад асуултуудтай харьцуулахад хамгийн бага санал өгсөн бол чанарын судалгаанд хамрагдагсад үүнтэй ойролцоо хариултыг зөвхөн ганц хүн л хэлжээ. Тэгэхээр хоёр судалгаа аль аль нь иргэд хуулиа мэддэг байх нь төдийлэн үр дүнд хүргэхгүй. Харин хяналт, зөвшөөрлийн олон шаттай тогтолцоо хүмүүсийг авилгал руу түлхээд байна. Мөн хуулийн заалтаа авилгал авагсад руу илүү чиглүүлээч гэж үзээд байгаа тал харагдаж байлаа.

Хүснэгт 1. Судалгаанд хамрагдсан хүн амын хувь, авилгалыг өөгшүүлэхэд нөлөөлж буй улс төрийн хүчин зүйлсийг тодорхойлсон байдлаар

Авилгалыг өөгшүүлэхэд нөлөөлж буй улс төрийн хүчин зүйлс	Хувь	Тоо
Авилгал өгч улс төрийн өндөр албан тушаалд томилогдох	61.7	304
Сонгуульд нэр дэвшихийн тулд намд өндөр албан татвар төлөх	38.3	189
Улс төрийн намын санхүүжилтын механизм хуулиар нарийн зохицуулагдаагүй	26.0	128
Улс төрөөр хөөцөлдөж эдийн засгийн чадавхаа сайжруулдаг буруу тогтолцоо хэвшил болсон	55.2	272
Мөнгө ба улс төр хэтэрхий хутгалдсан	33.1	163

Тэмдэглэл: Давхардсан хариулттай тул 100 хувьд барихгүй

зүйн орчныг бүрдүүлэх хэрэгтэй. Чухам юуг авилгал гэх вэ гэдэг хуулийн заалтаа боловсронгуй болгох хэрэгтэй. Чихрийн цуглуулга, дарс гэх мэт жижиг зүйлийг яриад цаана нь байгаа маш том авилгалын асуудал сүүдэрт нь үлдээд байна. Хэтэрхий их дүрэм журам батлаж нэг байгууллагад хэтэрхий олон янзын хяналт тавьдаг нь дахиад л авилгалын нэг үндэс суурь болоод байна. Зах зээлийн харилцаа нь өөрийн жам ёсоороо хөгжвөл авилгал алга болох

Авилгалыг өөгшүүлэхэд нөлөөлж буй улс төрийн хүчин зүйлийг иргэд юу гэж үзэж байгааг одоо авч үзье. Тоон судалгаанд хамрагдагсдын 61.7 хувь нь авилгал өгч улс төрийн өндөр албан тушаалд томилогдох, 55.2 хувь нь улс төрөөр хөөцөлдөж, эдийн засгийн чадавхаа сайжруулдаг буруу тогтолцоо хэвшил болсон, 38.3 хувь нь сонгуульд нэр дэвшихийн тулд намд өндөр албан татвар төлөх, 33.1 хувь нь мөнгө ба улс төр хэтэрхий хутгалдсан, 26.0 хувь нь улс


төрийн намын санхүүжилтийн механизм хуулиар нарийн зохицуулагдаагүй гэсэн хариулт өгчээ. Бидний явуулсан энэхүү тоон судалгаагаар 4-өөс дээш сонгож бөглөх асуултан дээр хамгийн их хувиар санал нэгдэж байгаа хариулт нь эхний хоёр тоон үзүүлэлт болж байна. Тэгэхээр иргэд маань авилгал гэдэг зүйлийг хамгийн их өөгшүүлдэг хүчин зүйлд улс төрийн хүчин зүйлийг л оруулж ирж байна (Хүснэгт 1). Төрийн зарим албан тушаал авлигаар хэн нэгэнд хуваарилагддаг гэсэн нийгмийн сэтгэл зүй хүчтэй хэвээр байгааг энэ асуудлын хувьд хамгийн өндөр хувийг эзлэж байгаа авилгал өгч байж өндөр албан тушаалд томилогддог гэж үзсэнээс харж болох юм.

Улс төрийн эрх мэдэл, албан тушаал, давуу байдал мөнгө, санхүү, бизнесийн аливаа үйл ажиллагаатай салшгүй уялдаатай болж байгаа нь улс төр бохирдож, хээл хахууль, авилгал улам тархаж буйг илэрхийлж байна. Энэ асуудлаар ч судалгаанд оролцогсдын талаас илүү хувь нь санал нийлж байгааг дээрх дүн батлаж байна. Чанарын судалгаанд оролцогсод дээрх асуултанд хариулахдаа улс төрчдийн дунд маш том сүлжээ байна, тиймээс илрүүлэлт маш бүрхэг. Улс төрийн намын санхүүжилт буруу, иймээс намд хандив нэрээр авилга өгч байна. Намын удирдлага, Засгийн газрыг бүрдүүлэх гэх мэт томоохон халаа сэлгээ нь авилгалтай холбоотой. Нам ямар хүнийг ямар албан тушаалд тавихаа мэддэг гэсэн хариултуудыг өгчээ. Түүнчлэн, улс төрчдийн дунд ашигтай байр суурийн төлөөх тэмцэл болж байна. Түүнийг

илрүүлэх боломжгүй, илрүүлэлт ч бүрхэг, улс төрчид төрийн өндөр албан тушаалыг эдийн засгийн өөрөөр хэлбэл, гаргасан зардлаа нөхөх арга хэрэгслэл болгож байна гэж үзэж байна. Тоон болон чанарын судалгаанд хамрагдагсад маш их ойролцоо хариулт өгсөн нь эндээс тодорхой харагдаж байна. Улс төрийн хүрээнийхний албан тушаалын төлөөх өрсөлдөөн, өндөр албан тушаалаар дамжуулж эдийн засгийн чадавхаа дээшлүүлэх гэсэн санаархал, улс төрийн намын үйл ажиллагаагаа явуулах механизм гишүүнчлэл зэрэг нь нийгмийн аль ч хэсгийнхэнд хамгийн их ойлгомжтой авилгалын сүлжээ үүсгэсэн гэж нийт судалгаанд оролцогсод үзсэн байна. Чанарын судалгаанд үүнийг үгүйсгэсэн, өөр хувилбар гаргасан нэг ч санал гараагүй байна.

Монгол Улсын Үндсэн Хуулийн 16-р зүйлийн 14 дэх хэсэгт "...Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно" гэж заасан байдаг. Хуулийн энэ заалт нь энэхүү хуулийн 49-р зүйлийн 1 дэх хэсэгт байх "Шүүгч нь хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана" гэсэн заалтыг биелүүлж байж л нийгэмд шударга ёсыг тогтоож чадах юм. Гэтэл сүүлчийн заалт нь биелэгдэхгүй байгаа учраас эхний заалт нь гэм буруутан, авилгачдыг хаацайлах

Зураг 6. Судалгаанд хамрагдсан хүн амын хувийн жин, авилгалыг хориглоход чиглэсэн улс төрийн чухал алхамуудаар




хууль эрх зүйн орчин болж хувираад байна⁴. Авилгалыг багасгах, хориглоход чиглэсэн улс төрийн чухал алхмуудаар дараахь зүйлсийг нэрлэжээ. Зураг 6-аас харахад судалгаанд оролцогсдын 45.4 хувь нь “Улс төрчдийн орлогын мэдүүлгийг нийтэд нээлттэй болгох”, 30.6 хувь нь “Намд хандив өргөх замаар сонгуульд нэр дэвшдэг байдлыг өөрчлөх”, 21.9 хувь нь “Намын санхүүжилтын орчинг сайжруулахад чиглэсэн хуулийг гаргаж хэрэгжилтэд дээд зэргээр анхаарах”, 2.0 хувь нь “Төрийн албан хаагчдыг намын харьяалалгүй болгох” зэргийг нэрлэжээ. Орлогын мэдүүлгийн талаар нааштай алхмууд хийгдэж эхэлж байгаа нь сайшаалтай. Гэвч энэ нь улс төрчдийн хувьд ялангуяа, УИХ-ын гишүүдийн хувьд авч үзвэл зайлшгүй шинжтэй бус харин боломжит, сонголтот шинжтэй байгаа нь авилгалаас ангид байх боломжгүй гэсэн ойлголт нийгэмд хүчтэй хэвээр байх гол хүчин зүйлийн нэг болж байгаа юм. Намын санхүүжилтын зарчим,

дүнгийн энэхүү хувь хэмжээнүүд илчилж байна.

Авилгалыг дэмжин дэлгэрүүлэхэд нөлөөлж буй эдийн засгийн хүчин зүйлсийг тоон судалгаанд хамрагдагсад дараахь байдлаар нэрлэсэн байна. Зураг 7-гоос харахад иргэдийн орлогын тэгш бус байдал гэж нийт оролцогсдын 29.6 хувь, эдийн засаг дахь цөөнхийн монопольчлол болон амьжиргааны чадавхи сул гэж тус бүр 20.3 хувь, ажлын байрны эрэлт их гэж 17.4 хувь, тендэрийн шударга бус өрсөлдөөн гэж 11 хувь, хүний шунал хэтэрсний улмаас гэж 1.4 хувь нь тус тус санал өгчээ. Тоон судалгаанд хамрагдагсад өмнө гарч байсан асуултуудад маш их өндөр хувьтайгаар хариулт өгч байсан нь энэ асуултын хариултанд харагдахгүй байгаа нь авилгал бий болгоод байгаа эдийн засгийн хүчин зүйлүүд дээр харьцангуйгаар өөр өөр байр суурьтай байгааг харуулж байна.

Зураг 7. Судалгаанд хамрагдсан хүн амын хувийн жин, авилгалыг дэмжин дэлгэрүүлэхэд нөлөөлж буй эдийн засгийн хүчин зүйлийг нэрлэсэн байдлаар



хэмжээ, хандив өргөх асуудал холбогдох хуулинд хэрхэн тусгагдсаныг баримт материалын шинжилгээний хэсэгт өмнө дурьдсан билээ. Агуулгын хувьд боломжийн хуультай орон болох нь харагдаж байгаа ч хэрэгжилтийн асуудал олон нийтийн хувьд хангалтгүй хэвээрээ байгааг судалгааны

Чанарын болон тоон судалгааны үр дүн хамгийн их зөрөөтэй гарсан асуулт энэ байлаа. Тоон судалгаан дээр хамгийн өндөр хувьтай гарч байсан хүмүүсийн орлогын тэгш бус байдал гэсэн шалтгааныг чанарын судалгаан дээр бараг

⁴ Үндсэн хуулийн дурдсан заалтуудыг харна уу.

дурдсангүй. Харьцангуй өндөр хувьтай гарч ирж байсан ажлын байрны эрэлт гэсэн хариулт чанарын судалгаан дээр огт дурдагдсангүй. Тэгэхээр чанарын судалгаанд оролцогсод энэ хариултуудыг авилгал үүсгэх эдийн засгийн хүчин зүйлд оруулж үзсэнгүй гэж үзэж болох талтай. Харин тоон судалгаан дээр харьцангуй бага хувьтай гарч байсан тендэрийн шударга бус өрсөлдөөнийг чанарын судалгааныхан нэлээд түлхүү авч үзжээ. Тухайн үедээ эрх мэдэлтэй байгаа хүн өөртөө ашигтайгаар л асуудлыг шийдэж байна. Тендэрийн хаалттай байдал, шударга бус өрсөлдөөн л авилгалыг бий болгож байна гэж хариулжээ. Тоон судалгаанаас нэлээд ялгаатай либерал эдийн засаг нь өөрөө авилгалыг үүсгэж байна гэсэн хариулт ч гарч ирж байлаа. Тоон судалгаан дээр хүмүүсийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх нь авилгалыг алга болгоно гэсэн хариулт илүү түлхүү харагдаж байсан бол чанарын судалгаанд амьжиргааны түвшний өсөлт нь авилгалыг хориглогч хүчин зүйл болохгүй, учир нь орлогоосоо хамаарч хэрэглээ өндөр болж байдаг тул авилга үүнээс хамаарч өөрчлөгдөхгүй гэсэн хариулт нэлээд гарч байлаа. Чанарын судалгаанд оролцогсод гадаадаас ирж байгаа зээл тусламжийн хуваарилалт нь авилгалыг өөгшүүлж байгаа нэг чухал хүчин зүйл болж байна. Тэр зээл тусламж нийгэм рүү биш эрх мэдэлтний халаас руу орж байна гэсэн байх юм.

Эцэст нь авилгалыг өөгшүүлэхэд нөлөөлж буй зан заншил, ёс суртахууны хүчин зүйлсийг нийгэм хэрхэн үнэлж байгаа авч үзье. Чанарын судалгаанд оролцогсод хүмүүсийн ёс суртахууны үүрэг хариуцлагын талаар тоон судалгаан дээр хамгийн өндөр хувь авч байсан хариултыг нэг их гаргаж тавьсангүй. Харин ч хувийн хэвшлүүд эдийн засгийн хувьд хүчирхэг болоод ирвэл ёс суртахууны хүчин зүйлүүд өөрөө зохицон бий болно. Ёс суртахууны хүчин зүйл хамгийн сүүлд л нөлөөлнө гэсэн сонин хариулт өгч байв. Тэр ч

байтугай өнөөгийн ийм нөхцөл байдал нь ямар ч ёс суртахууны хувьд цэвэр хүнийг сайндаа л гурван жил л авилга авахгүй байлгана. Тэгээд л бусдын адил авилгалаа авдаг л болгоно шүү дээ гэжээ. Тэгэхээр чанарын судалгаанд оролцогсод хүний ёс суртахууны хүчин зүйл нь авилгалыг алга болгохгүй харин нийгмийн хүчин зүйл нь л илүү нөлөөтэй гэж үзжээ.

Дүгнэлт

Бидний судалгааны зорилго маань авилгалыг ямар албан тушаалтан, аль улс төрийн хүчин авч байна, авилгалын индекс ямар түвшинд байна гэх зэрэг өмнө өөр өөр байгууллагууд нэлээд олон удаа хийсэн судалгааг дахин нотлох явдал биш байсан. Харин яаж энэ авилгалыг арилгах вэ, түүнийг алга болгоход юу юу нөлөөлж болох вэ гэдэг дээр олон түмний санаа бодлыг гаргаж харуулахад голлон анхаарсан. Тиймээс бид иргэдийн өөрсдийн нь үйл байдалтай холбоотой, төрийн үйл ажиллагаагаа явуулах механизм, албан тушаалтнуудын үйл ажиллагаа, хууль эрх зүйн талын гэх мэт нөлөөлөх хүчин зүйлүүдтэй холбоотой асуултуудыг тавьж судалгаагаа явуулсан билээ.

Британийн судлаач Фрэнк Паркин өмч бол нийгмийн цөөнх хэсэг монопольчилж, эрх мэдэлдээ хүрэхэд ашигладаг социал саад гэж үзэж, энэ социал саадын тусламжтайгаар бүлгүүд нөөц баялгийг зөвхөн өөрөө хянах, бусдын боломжийг хязгаарлах гэж оролддог гэж үзэж байжээ. Харин Вебер социал саад бий болгоход өмчөөс гадна угсаатны хамаарал, хэл, шашин зэрэг статусын ялгааг ашиглаж болдог гэжээ. Өнөөгийн монголын нийгэмд өмч, баялгийн хуваарилалтанд ноёрхож байгаа бүлэглэлүүд эрх мэдлийг хуваарилан авах хандлага байгааг үгүйсгэх аргагүй. Ардчилал нь үүнийг хязгаарлан барих нэг нөхцөл болж байгаа боловч төдийлөн үр дүнд хүрч чадахгүй байгаа юм. Тийм ч учраас авилгал, хээл хахуулийн асуудал нийгмийн хамгийн

эмзэг асуудал болж, түүнийг шийдвэрлэх явдалд дорвитой ахиц гарахгүй байна. Тийм учраас энэ бүлэглэлүүдийн зүгээс нийгмийн баялгийг шудрага бусаар хянаад байгаа байдлыг өөрчлөх нь маш чухал алхам юм. Ийм өөрчлөлт хийхийн тулд авилгалын асуудлыг таслан зогсоох талаар амжилтанд хүрсэн бусад орнуудын практик, туршлагыг судлах нь нэн шаардлагатай юм. Энэ асуудлыг тухайлбал, авилгалын эсрэг олон улсын Транспаренси Интернейшнл байгууллагын судалгааны дүнтэй харьцуулан авч үзвэл сонирхолтой дүр зураг гарч ирэх болов уу.⁵

Судалгаанд хамрагдагсад авилгалыг таслан зогсооход чиглэсэн хатуу хууль гаргаж хэрэгжүүлэх гэсэн хүчин зүйлийн 90.3 хувь нь маш их ач холбогдолтой, болон ач холбогдолтой гэж үзжээ. Энэ нь нийт ард иргэд авилгал гэдэг энэ гаж үзэгдлээс залхсан, түргэн салахыг эрмэлзсэн, өөрсдийнх нь амьдрал үйл ажиллагаанд үргэлж саад тотгор болж байгааг их мэдрэх болсонтой холбоотой юм. Түүнээс гадна авилгалын асуудлыг олон жил яриад л байсан тэр нь тодорхой үр дүнд хүрсэн нь харагдахгүй, байдал улам л дордож байгаагаас улбаатай болов уу. Иймээс өөрийн эрх ашгийг хамгаалахын тулд бүгдэд хатуу хариуцлага тооцох, авилга өгч авалцсан тохиолдолд хэнийг ч ялгалгүй шийтгэх, магадгүй өөрөө ч байсан ийм шийтгэл хүлээхээс татгалзахааргүй болжээ. Өөрөөр хэлбэл нийгэм бүхэлдээ Гоббсын хэлж байсанчлан “чи эрхээ шилжүүлбэл би ч гэсэн эрхээ шилжүүлнэ” гэж тохироход бэлэн байгаа нь харагдаж байна. Энэ нь авилгал маш их болсон, түүнийг нийгэм ерөөсөө шийдэж чадахгүй байгааг л харуулах үзүүлэлт мөн.

Тоон судалгаанд оролцогсад авилгалыг өөгшүүлэгч эдийн засгийн хүчин зүйлсэд иргэдийн орлогын тэгш бус байдал гэж 29.6 хувь нь үзсэн. Гэтэл чанарын судалгаанд оролцогсад энэ үзүүлэлтийг

дурдсангүй. Тоон судалгаанд оролцогсад ч гэсэн бусад хүчин зүйлсийг авч үзэхдээ маш өндөр хувиар санал нэгддэг байсан байдал нь энд харагдахгүй байгаа юм. Судалгаанд хамрагдагсдын санаа бодол дээр судалгааны багийнхны үзэл бодлыг нэмж тооцвол энэ нь тийм ч чухал хүчин зүйл болохгүй гэж үзмээр байна. Учир нь хэн нэг нь нөгөөгөөсөө илүү баян болоод юм уу эсвэл эсрэгээрээ ядуу болоод авилга өгөөд байгаа биш юм. Хэрвээ асуудлыг тийм байр сууринаас авч үзвэл орлого нь тэнцүү болчихвол авилга алга болох юм байна гэсэн дүгнэлт гармаар байгаа юм. Амьжиргааны чадавхи сул байгаа нь авилга өгөхөд нөлөөлж байна гэж тоон судалгаанд оролцогсодын 20.3 хувь нь үзэж байна. Гэтэл хамгийн их авилга өгч, нийгэмд хамгийн их хохирол учруулаад байгаа хэсэг маань нийгмийн эмзэг, амьжиргаа муутай хэсэг биш харин ч их хэмжээний капитал хуримтлуулсан баян чинээлэг хэсэг шүү дээ. Тийм ч учраас чанарын судалгаанд оролцогсад либерал эдийн засаг, эдийн засаг дахь цөөнхийн монопольчлол, тендэрийн шударга бус өрсөлдөөнийг авилгал бий болгох эдийн засгийн хүчин зүйл гэж үзсэн болов уу. Мэдээж либерал эдийн засаг нь өөрөө өрсөлдөөнийг бий болгож, баялгийн тэгш бус хуваарилалтанд хүргэх нь гарцаагүй. Харин өрсөлдөөнийг шударга байлгах бололцоог бүрдүүлж өгөх нь төр засгийн үүрэг байх ёстой юм. Гэтэл одоо эдийн засгийн хувьд чадавхитай болсон хэсгийнх нь талд төрийн аппаратад ажиллаж байгаа албан тушаалтнууд үйлчилж, улс төр эдийн засгийн олигархи бүлэглэл бий болоход хүргээд байна.

Тоон судалгаа чанарын судалгаа хоёрын үзүүлэлт хамгийн их зөрөөтэй гарч байгаа асуудлуудын нэг нь зан заншил, ёс суртахууны хүчин зүйлсийн талаар байлаа. Тоон судалгаанд оролцогсад 60.4 хувиар хүмүүсийн ёс суртахууны үүрэг хариуцлага суларсан нь авилгалыг

⁵ Transparency International: the global coalition against corruption, available at <http://www.transparency.org/>

өөгшүүлж байна гэж үзсэн бол чанарын судалгаанд оролцогсод нь ёс суртахууны хүчин зүйл бараг нөлөөлөхгүй, нөлөөлөх байсан ч бусад хүчин зүйлтэй харьцуулахад хамгийн сүүлд л нөлөөлнө. Нийгэм нь өөрөө ямар ч шударга хүнийг эвдээд байна шүү дээ гэсэн хариулт өгч байна. Нэгэнт судалгаанд оролцогсод ихээхэн зөрүүтэй хариулт өгч байгаа тул судалгааны багийнханд асуудлыг тайлбарлахад нэлээд бэрхшээлтэй байлаа. Гэхдээ нийгэмд саар зүйлийн хажуугаар сайн зүйл их байгаа. Хэрвээ ард иргэд төр засгаа сонгох эрхээ эдлэхдээ өөрсдөө хариуцлагатай хандаж үнэхээр ард олноо гэсэн сэтгэлтэй шударга хүмүүст эрх мэдлийг хүлээлгэж чадвал тэдний ёс суртахууны үнэт зүйлс нь нийгмийг цэвэршүүлэхэд үүрэг гүйцэтгэж чадах нь гарцаагүй гэж үзмээр байна.

Чанарын болон тоон судалгаа хоёулаа монголын нийгэмд авилгал түгээмэл үзэгдэл болсныг харуулж байна. Судалгаагаар авилгалыг илрүүлж чадахгүй байгаагийн учир шалтгаан юу вэ гэсэн асуултанд оролцогсдын 52 хувь нь төрийн байгууллага, албан тушаалтнууд авилгалд идэгдчихсэн, хоорондоо холбоо сүлбээтэй болчихсон, бие биенээ хамгаалдаг болчихсон байдал гэж үзэж байна. Тийм ч учраас авилгал, хээл хахуулийн асуудал нийгмийн хамгийн эмзэг асуудал болж, түүнийг шийдвэрлэх явдалд дорвитой ахиц гарахгүй байна. Судалгааны дүнгээс харахад олон түмэн авилгалтай тэмцэх ажлыг илүү оновчтой үр дүнтэй болоосой гэж хүсч явдаг нь харагдаж байна.

Ашигласан материал

Ардчиллыг шинээр болон сэргээн тогтоосон орнуудын олон улсын V бага хурал.: Судалгааны ажлууд ба төгсгөлийн баримт бичгүүдийн эмхэтгэл, УБ., 2003

Жереми Поуп, Авилгалын эсрэг сурвалж бичиг, УБ., 2003.

Зориг сан, Авилгал ба төрийн албан хаагчид" төслийн тайлан, УБ., 2001

Зориг сан, Боловсролын байгууллага дахь авилгал, 2006.

Марк Грамбергер, Иргэн түншлэгч болох нь: Бодлого боловсруулах явцад мэдээлэх, зөвлөлдөх, олон нийтийг оролцуулах, 2003.

Монголын нээлттэй нийгэм хүрээлэн, 2004 оны УИХ-ын сонгуулийн компанит ажлын санхүүжилтийн мониторинг: тайлан, 2004.

МҮХАҮТ, Авилгалын индекс: судалгааны тайлан, 2002.

МҮХАҮТ, Авилгалын эсрэг тэмцэлд хэвлэл мэдээллийн байгууллагуудын оролцоог эрчимжүүлэх нь: товхимол, 2002

НҮБХХ, Авилгалтай тэмцэх үйл ажиллагааны бүтэц, зохион байгуулалт: харьцуулсан судалгаа, 2005.

НҮБХХ, Авилгалын эсрэг хамтдаа: орон нутагт хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, 2006.

Нээлттэй нийгэм форум, Монгол дахь авилгалын асуудалд холбогдох ном зүй, 2005.

ОУХА, Монгол улс дахь авилгалын байдалд хийсэн үнэлгээ: эцсийн тайлан, 2005.

Памела Слуц, Монголд авилга байгаад зогсохгүй улам томорч байна, Өдрийн сонин, Илгээлт, 2005.05.13, № 115, 3-р нүүр.

Цэрэндорж Д., Улс төрийн хүрээний авилга сонгуулиас эхэлдэг, "Өнөөдөр", 2004.01.09, № 006, 5-р нүүр.